



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2018 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

“Хөдөлгөөн –Эрүүл мэнд” спорт өдөрлөгийн
үйл ажиллагааны зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 тоот тогтоолын 4.1.25 заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/264, А/295 дугаар тушаалыг үндэслэн, Төвийн захирлын 2018 оны А/38 тоот тушаалын хавсралт “Нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Хөдөлгөөн Эрүүл мэнд” сэдэвт спортын өдөрлөгийн хавсралтаар баталсугай.
2. Дээрх үйл ажиллагааны зардал 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Ахлах нягтлан бодогч /С.Алтаннамар/-т зөвшөөрсүгэй.
3. Байгууллага хамт олны сахилга дэг журам, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Спорт, олон нийтийн багийн ахлагч Д.Наранхүүд үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

БАТЛАВ.
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР



“Хөдөлгөөн-Эрүүл мэнд” спорт өдөрлөгийн удирдамж

2018.08.08

1. Зорилго:

ЦССҮТ-ийн захирлын 2018.08.06-ний өдрийн А/38 тоот тушаалын “Нийгмийн хамгааллыг дэмжих сар” аяны хүрээнд ЦССҮТ-өөс Эмнэлгийн ажилчдын баярыг тохиолдуулан нийт ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн болон бие бялдрыг чийрэгжүүлэн эрүүл мэндийг нь дэмжих, эвсэг хамт олон бүрдүүлэхэд гол зорилго оршино.

2. Хамрах хүрээ:

ЦССҮТ-ийн нийт эмч, эмнэлгийн ажиллагсад хүний тоо /68/

3. Хэзээ:

2018 оны 08-р сарын 10-11-ний өдөр

4. Хаана:

Тэрэлж, Мэлхий хад Тэлмэн амралтын бааз

5. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2018.08.10-2018.08.11-ны хооронд явган аялал, спортын 3 төрөлт тэмцээн, хөгжөөнт тэмцээн уралдаан зохион байгуулагдана.

2018.08.11-ний өдрийн 10⁰⁰ цагаас спортын тэмцээнүүд цагийн хуваарийн дагуу зохион байгуулагдана.

6. Үйл ажиллагааг зохион байгуулах нэгж:

ЦССҮТ-ийн Олон нийтийн баг

u



ЦУС СЭЛБЭЛТ СУДСАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/38


Улаанбаатар хот

Нийгмийн хамгааллыг дэмжих сарыг
зохион байгуулах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/264, А/295 дугаар тушаал, төвийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.3.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн хэмжээнд жил бүрийн 8 дугаар сарыг "Ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар" болгон, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайланг 9 дүгээр сарын 10-ны дотор төвийн Удирдлагын зөвлөлд танилцуулан, 9 дүгээр сарын 15-ны дотор ЭМЯ-нд хүргүүлэхийг Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны албаны дарга Н.Янжиндуламд үүрэг болгосугай.
3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хууль, журмын дагуу зарцуулахыг Ахлах нягтлан бодогч С.Алтаннамарт зөвшөөрсүгэй.
4. Уг тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор Д.Амарт даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

“ Хөдөлгөөн эрүүл мэнд ” ажилчдын спорт өдөрлөгийн хавсралт

“ Хөдөлгөөн эрүүл мэнд ” ажилчдын спортын
өдөрлөгийн төсөв

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төг/
1	Унааны зардал	1	300000	300000
2	Амрах байр	7	50000	350000
3	Цэвэр ус /500мл/	100	1000	100000
4	Хоол /өдрийн/	50	15000	750000
	Нийт дүн			1500000

Төсөв гаргасан: НЛТ-ийн лаборант

Хянасан: СТСБА-н ахлах нягтлан бодогч



Д.Энхсүрэн

Ш.Алтаннамар